

Байцаалтын үйл ажиллагаа явагдахаас өмнөх таны эрхийн тухай таницуулга

1. Байцаалтанд орохоос өмнө та өмгөөлөгчтэй уулзаж нууц зөвлөгөө авах ба байцаалтны явцад өмгөөлөгч байлцуулах тухай

A. Өмгөөлөгч

- Та өмгөөлөгчөө сонгож болно.
- Хэрэв та өөрийн өмгөөлөгчгүй ба өмгөөлөгчтэй уулзах боломжгүй бол өмгөөлөгчийн албатай холбогдож танд жижүүрийн өмгөөлөгч олгоно.
- Та хөнгөлттэй болон үнэгүй өмгөөлөгч авах хуулиар шаардсан болзолын тухай мэдээлэл баримтыг хүсэж болно.

B. Байцаалт явагдахаас өмнө өмгөөлөгчтэй уулзаж нууц зөвлөгөө авах тухай

- Танд олгосон болон таны өөрийн өмгөөлөгч дуудсанаас хойш 2 цагийн дотор ирэх ёстой. Та өмгөөлөгчөөс 30 минутын хугацаатай нууц зөвлөгөө авах эрхтэй. Байцаагчийн зөвшөөрөлтэйгээр онцгой тохиолдолд уулзах хугацааг сунгадаг.
- Нууц зөвлөгөөг утсаар болон биеээр уулзаж авч болно.
- Хэрэв та 2 цагын дотор олгогдсон ба өөрийн өмгөөлөгчөөс нууц зөвлөгөө авч амжихгүй бол жижүүрийн өмгөөлөгчтэй холбогдож утсаар зөвлөгөө авах эрхтэй. Нууц зөвлөгөө явагдсаны дараа байцаалт эхэлнэ.
- Хэрэв өмгөөлөгч тогтсон цагаасаа хоцорвол, байцаалтанд ирсэн цагаасаа хойш байлцах эрхтэй.

C. Байцаалтны явц дахь өмгөөлөгчийн тусламж

- Та байцаалтны явцад өмгөөлөгч байлцуулах эрхтэй.
- Байцаалтны явцад өмгөөлөгч дараах зүйлийг хянах болно.
 - Таны дуугүй байх эрх ба эрүүг тулган хүлээлгэж байгаа талаар хянах
 - Бие махбодийн буюу сэтгэл санааны дарамтад оруулж байгааг
 - Таны эрхийг хамгаалж байцаалт үргэлжлэх хугацааг хянана

Өмгөөлөгчийн гаргасан гомдолыг бичиж тэмдэглэх ёстой.

Өмгөөлөгч таны өмнөөс асуултанд хариулж байцаалт явагдахад хүндрэл учруулж болохгүй. Асуултыг дахин тодруулах тавих хүсэлт тавих эрхтэй.

- Та болон таны өмгөөлөгч байцаалтыг 1 удаа завсарлуулж дахин нууц зөвлөгөө өгөх авах хүсэлт тавих эрхтэй. Зөвлөгөө 15 минутаас илүү үргэлжилж болохгүй.

D. Өмгөөлөгчийн тусламж татгалзах

Та заавал өмгөөлөгчөөс нууц зөвлөгөө авах ба заавал байцаалтны явцад байлцуулах ёсгүй.

Та дараах тохиолдолд өмгөөлөгчийн тусламж зөвлөгөө авах эрхээсээ татгалзаж болно.

- Та насанд хүрсэн бол
- Та жижүүрийн өмгөөлөгчөөс утсаар нууц зөвлөгөө авсаны дараа
- Та татгалзсан баримтанд гарын үсгээ зурж, он сар өдөр бичигдэж бол

Байцаалтны үйл явцад видео бичлэг хийх хүсэлт гаргах эрхтэй, өмгөөлөгчтэй энэ талаар зөвлөлдөж болно.

E. Өмгөөлөгчийн зөвлөгөө авах эрхийг хорих

Зайлшгүй тохиолдолд мөрдөн шүүгч болон Вант улсын прокурорь таны өмгөөлөгччөөс нууц зөвлөгөө авах болон байцаалтанд өмгөөлөгч байлцуулах эрхийг хорьж болно. Эрх хорьсон шийдвэрийн шалтгаанаа тодорхойлох ёстой

F. европын улсуудад зарласан баривчлан хорих тушаал гаргасан орноос өмгөөлөгч авах эрхтэй.

Та Европын улсуудад зарласан баривчлан хорих тушаалын дор хоригдсон бол уг улсаас өмгөөлөгч авах эрхтэй. Уг улсын өмгөөлөгч таныг өмгөөлж байсан Бельги улсын өмгөөлөгчөөс шилжүүлэх өгөх талаар мэдээлэл ба зөвлөгөө авч болно

2. Европын улсуудад зарласан баривчлан хорих тушаал ба эрэн сурвалжилж байгаа талаарх мэдээлэл авах эрх

- Та Европын улсуудад зарласан баривчлан хорих тушаал ба эрэн сурвалжилж байгаа агуулгын талаар мэдээлэл авах эрхтэй.
- Таны ялыг эдлүүлэхээр уг улс уруу шилжүүлэх тохиолдолд та хүлээлгэсэн хуулийн ял шийтгэлтийн талаар болон хуулийн ял шийтгэлийн процедурьны талаар мэдээлэл аваагүй бол хэргийн зүйл анги, ял эдлүүлэх болзолын тухай мэдээлэл авах эрхтэй. Мөн ялын тогтоолын баримтны хувилбарыг авах хүсэлт гаргах эрхтэй.

3. Дуугүй байх эрх

- Та хэргийг хүлээх албагүй
- Та өөрийгөө танилцуулсаны дараа мэдүүлэг өгөхөөс татгалзах ,асуултанд хариулах ба дуугүй байхыг сонгож болно.

4. Цагдааг дээр хорьж саатуулагдсан тухай хэн нэгэнд мэдэгдэх эрх

Та 1 хүнд хоригдсон болохоо мэдэгдэх эрхтэй.

Мөрдөн шүүгч болон Вант улсын прокурорь мөрдлөгийн үйл ажиллагааны ашиг сонирхлын улмаас, зайшгүй шалтгаанаар хэн нэгэнд мэдэгдэх эрхийг хойшлуулах шийдвэр гаргаж болно.

5. Эрүүл мэндийн тусламж авах эрх

- Шаардлагатай тохиолдолд та үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж авах эрхтэй
- Та өөрийн хүссэн эмчийн тусламж авч болно. Энэ тохиолдолд төлбөрийг өөрөө төлнө

Байцаалтны явцад үйлчлэх эрх

6. Өөр бусад эрх

Байцаалтны эхний шатанд дуугүй байх эрхийн тухай, байцаалт авах шалтгааны товч тайлбарыг дахин танилцуулахаас гадна дараах зүйлийг мэдээллэнэ.

- Та байцаагчын асуусан асуулт, таны хариулсан үг бүрийг нэг бүрчлэн бичихийг хүсэмжилж болно.
- Та мөрдлөгийн үйл ажилагаа ба байцаалт явуулах хүсэлт гаргаж болно.
- Таны мэдүүлэг бичгэн баримт болон хавсрагдах хүсэлт гаргах.
- Та байцаалтыг хойшлуулахгүйгээр өөрт байгаа холбогдолтой гэж үзсэн баримт бичгийг өгч болно. Энэ баримт бичгүүдийг мэдүүлэгийн хамт хавтаст хэрэгт хавсаргаж шүүхийн тамгийн газар хадгалах хүсэлт гаргаж болно.

7. Байцаалтны үйл явцад видео бичлэг хийх тухай эрх

- Боломжтой тохиолдолд байцаалтны үйл явцыг хянах зорилгоор видео бичлэг хийж болно.
- Байцаагч, Вант улсын прокурорь ба мөрдөн шүүгч видео бичлэг хийж болох тухай шийднэ.

8. Байцаалтны төгсгөл

Байцаалт явагдаж дууссаны дараа та мэдүүлгийг бүрэн эхээр нь дахин уншиж болно. Эсвэл уншуулж болно.

Дараа нь танаас нэмэх ба засах зүйл байна уу гэж асууна.

9. Орчуулагчийн тусламж авах тухай эрх

- Хэрэв та өмгөөлөгчтэй хэл ойлголцохгүй болон сонсгол ба хэл ярианы бэрхшээлийн улмаас харьцаж чадахгүй бол нууц зөвлөгөө итгэмжлэгдсэн орчуулагчаар орчуулагдаж явагдана. Орчуулагч төлбөргүй.
- Шүүхийн үйл ажиллагааг тодорхой хэл дээр явуулах хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд итгэмжлэгдсэн орчуулагч дуудаж байцаалт явагдана. Төлбөргүй.
- Мөн та эх хэлээрээ мэдүүлгээ бичгээр өгч болно.

10. Шилжүүлэн өгөхөд санал нийцэх

Та, таныг шаардсан улс уруу шилжүүлэн өгөх шийдвэрийг хүлээн зөвшөөрч болно. Европын орнуудад зарлагдсан баривчлан хорих тухайн тушаалд дурдсан шалтгаан таны зөвшөөрлийг хязгаарлаж болно.

Таныг шилжүүлэн авсаны дараа ял хэрэгжүүлэх, яллах бусад гэмт хэргээр баривчлан хорих шийдвэр гарч болно.

Та, таныг шаардсан улс уруу шилжүүлэн өгөх шийдвэрийг хүлээн зөвшөөрч болно. Вант улсын прокурорь ба мөрдөнгийн шүүгч танаас байцаалт авч танд үр дагаварын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Та өмгөөлөгч байлцуулж болно. Та зөвхөн прокурорын шилжүүлэн өгөх шийдвэрийг хүлээн зөвшөөрч болно.

Нэгэнт хуулиар шилжүүлэн өгөх шийдвэр гарсан бол буцалтгүй.

Таныг ямар хугацаагаар хорих вэ?

1. Зарчмын хувьд 48 цагаар хорьж саатуулна.

Таныг 48 цагийн хугацаатай хорьж саатуулах болно.

2. Мөрдөнгийн шүүгч

- 48 цагийн дотор таныг суллах эсвэл мөрдөнгийн шүүгч байцаалт авах тухай шийдвэр гарна. Мөрдөнгийн шүүгч таныг Европын орнуудад зарлагдсан баривчлан хорих тушаалын дагуу таныг хорьж саатуулах тухай шийдвэрлэнэ.
- Мөрдөнгийн шүүгч шийдвэрээ гаргахын өмнө танаас байцаалт авна. Байцаалтанд өмгөөлөгч байлцах бөгөөд мөрдөнгийн шүүгч өмгөөлөгчийн болон таны саналыг сонсох ёстой.

Хэрэв та насанд хүрсэн бол өмгөөлөгч байлцуулах эрхээсээ татгалзаж болно.

- Мөрдөнгийн шүүгч таныг хорьж саатуулах тушаал гаргавал та дараах эрхтэй болно.
 - Та өмгөөлөгчтэйгээ чөлөөтэй харьцах эрхтэй
 - 15 хоногийн дотор Зөвлөлийн танхимаар орж Европын орнуудад зарлагдсан баривчлан хорих тушаалын дагуу хорьж саатуулагдсан талаар авч хэлэлцэнэ. Энэ зөвлөлдөх танхимаас гаргасан шийдвэрийн эсрэг 24 цагийн дотор дээд шатны шүүхэд давж заалдаж болно. Шийдвэр 15 хоногийн дотор гарна.

- Зөвлөлийн танхимаар орохоос 1 өдрийн өмнө өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцаж болно. Давж заадсан тохиолдолд шүүх хуралаас 1 өдрийн өмнө хавтаст хэрэгтэй танилцаж болно.
- Өмгөөлөгч танд шүүхийн процедурийг талаар мэдээлэл өгнө.
- Хэрэв та Бельги улсын иргэн биш бол өөрийн улсын консулын байгууллагатай холбогдож болно.
- Хэрэв Европын орнуудад зарлагдсан баривчлан хорих тушаал бичэгдсэн хэл түүний өөр бусад хэлний орчуулгыг та ойлгохгүй бол итгэмжлэгдсэн орчуулагчаар бичгээр болон амаар орчуулуулагдах болно. Зарлигын чухал агуулгатай хэсгийг хэсэгчлэн амаар болон бичгээр орчуулсан орчуулгыг Зөвлөлийн танхимаар хэлэлцэхээс өмнө ба тушаал гүйцэтгэх хугацаанд багтаж танд орчуулсан баримтыг олгоно.

Энэ мэдүүлэгч иргэний эрхийн талаарх мэдээллийн хувийг танд зориулав.